



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 0/733

Баруун-Урт сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн хэмжээнд цэргийн бүртгэлийг 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 01 дүгээр сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. 2022 оны цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицерын бүртгэлийг зохион байгуулж явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай.

Дарга :	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга :	- Цэргийн штабын дарга
Гишүүд:	- Цагдаагийн газрын дарга
	- Статистикийн хэлтсийн дарга
	- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	- Цэргийн штабын дайчилгааны офицер
	- Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер

Нарийн бичгийн дарга :	- Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер
------------------------	--

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хошууч Ө.Баясгалан/-т ДААЛГАХ нь :

1. Цэргийн бүртгэлтэй холбогдолтой баримт бичгийн нууц хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулж удирдах.

2. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах журмын дагуу мэдээ, судалгааг бүрэн гаргаж тайланг холбогдох дээд шатны байгууллагуудад тогтоосон хугацаанд хүргүүлэх.

3. Сумдын цэргийн бүртгэл явуулах ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллах.

4. Цэргийн бүртгэлийн шаардлагын түвшинг үл хангасан, бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанл хариуцаага тооцох

4. Сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь :

1. Сумдын 18-50 насны I, II дугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд, бэлтгэл офицер, цэрэгт бүртгэл бүхий эмэгтэйчүүдийг бүртгэлд хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

2. Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний бүртгэл, бэлтгэл офицер, ахлагчийн бүртгэл, бэлтгэл байлдагч түрүүчийн бүртгэл, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний алба, онцгой байдлын албанд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр алба хаасан төрийн тусгай алба хаагчийн бүртгэл тус бүрээр нь цэргийн мэргэжлийн дугаар, регистрийн дугаар, боловсрол, оногдуулан бүртгэгдсэн, чөлөөт нөөцийн үлдэгдэл зэргийн судалгаа гаргах.

3. Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний бүртгэл /цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан иргэний бүртгэл, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэний бүртгэл, цэргийн жинхэнэ алба хаагаагүй иргэний бүртгэл, цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүдийн бүртгэл тус бүрээр нь регистрийн дугаар, боловсрол, цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр судалгаа гаргах.

4. Эрчүүд, идэрчүүд, ангийн буу, агт морь, ат, шар, хувийн өмчийн ердийн хөсөг, авто техникийн мэдээг тус бүр маягтын дагуу гаргах.


5. Цэргийн мэргэжлийн дугаарыг шинэчлэх, бүртгэлийн маягтын дагуу мэдээ, судалгааг үнэн зөв гаргаж заагдсан хугацаанд хүлээлгэн өгөх.

6. Бүртгэлд хамрагдаагүй цэргийн бэлтгэл үүрэгтэн, хариуцсан ажлаа хангалтгүй зохион байгуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох.

7. Цэргийн бүртгэл явагдах хугацаанд "COVID-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх бүхий л талын арга хэмжээг авч ариутгал халдваргүйтгэлийн журмыг чанд мөрдөж ажиллах.

Тав. Сумдын цэргийн бүртгэлийн мэдээ тушаах хуваарийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, хөрөнгийг Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Ариунжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ